

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 06 дугаар сарын 30

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 06 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн IX хуралдаан 6-р сарын 26-ны өдөр хуралдаж 12 асуудал хэлэлцэж 7 тогтоол батлан Хурлын хороодод 3 асуудлыг дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын ээлжит 17 дугаар хуралдаанаар “Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт баталж, газар тусгай хамгаалалтад авах тухай”, “Зарим газар нутгийг аймгийн тусгай хэрэгцээнээс чөлөөлж бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай” асуудлуудыг нэмж хэлэлцэхээр шийдвэрлэв.

2. Төв суурин газрын хамгаалалтын бүсийг тогтоох тогтоолоо.

3. Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцээд Хурлын эдийн засаг, төсөв санхүү, өмчийн бодлогын хороонд дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

4. Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд аймаг дахь Төрийн Аудитын газраас хийсэн аудитын тайланг сонсож аймгийн ИТХ-ын 17 дугаар Хуралдаанд танилцуулахаар дэмжив.

5. Сумын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт баталж, тухайн газрыг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай асуудлыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо, Нийгмийн бодлогын хороонд шилжүүлэв.

6. Аймгаас 2015-2020 онд баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд “Үр дүнтэй” гэж дүгнэсэн.

7. Сумдын ИТХ-ын хуралдааны шийдвэрт хяналт шинжилгээ хийсэн тухай асуудлын хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргалаа.

8. Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажиллаж үнэтэй хувь нэмэр оруулсан, мөн залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа иргэдийг Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсан.

9. Бичил уурхайн зориулалтаар газрыг аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай асуудлуудыг хэлэлцээд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд дүгнэлт гаргуулахаар шилжүүлэв.

Улсын Их Хурлын Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн Ерөнхий Хорооны 4-р сарын 14-ний өдрийн 20-р тогтоолоор Төв аймгийн Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Улсын Их Хурлын 14 дүгээр тойрогт 27 сумын сонгуулийн хороо, 96 хэсэгт нийт 867 төрийн албан хаагч, 300 орчим Цагдаа, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн ажилтнууд ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 71.14, 71.15 дахь заалтын дагуу аймгийн 27 сумын 96 хэсгийн хорооны 40 хэсэгт хяналтын тооллого явуулсан бөгөөд хяналтын тооллогоор зөрүү гараагүй санал тоолох төхөөрөмжийн дүнтэй таарсан.

Аймгийн хэмжээнд сонгууль 70 хувийн ирцтэй, 43828 иргэн санал өгснөөс 42.28 хувиар аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, 36.7 хувиар Ардчилсан намын дэд дарга Ц.Туваан, 36.1 хувиар Батлан хамгаалах Яамны сайд Н.Энхболд нар Төв аймгийнхаа төлөөлөл болж УИХ-ын гишүүнээр сонгогдлоо.

Цагаатгах ажлын талаар: Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн 6 хүний 241.0 сая төгрөгийн нөхөх олговрын мөнгийг шүүхээр тогтоосон үр хүүхдүүдийнх нь дансанд шилжүүлж, батламжийг гардуулан өгч, нөхөх олговрын тайланг сар бүр төв комисст хүргүүлж ажиллалаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Ч.Санжаа, Д.Лувсандамба, Д.Галсанжамц, Д.Шарав, Ц.Ваанчиг, Ц.Дашзэвэг, Б.Гэндэнжав, Ц. Жамьяанжамц, О.Чимэд, Ц.Бадамжав, Ц.Цагаан, Д.Маналжав, Д.Гүрсэд, Д.Дамба, Д.Мандал нарын нөхөх олговор гаргуулах тогтоолыг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх гаргасан бөгөөд холбогдох баримтын хамт ЦАУЗБ улсын комисст хүргүүлсэн.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Аймгийн Засаг даргын зөвлөл 6 дугаар сарын 19-ний өдөр хуралдаж 10 асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

“Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 2 дугаар улирлын байдлаар 68.33%-тай гарсан бөгөөд зохион байгуулах хорооны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар Ерөнхий сайдын батламжаар аймгийн Засаг даргад өгсөн 6 үүргийн хэрэгжилт 90.0%-тай, Шадар сайдтай байгуулсан гэрээний биелэлт 90.0%-тай, ЗГХЭГ-ын даргатай АЗД-ын байгуулсан 2020 онд хамтран ажиллах гэрээний 22 заалтын хэрэгжилт 85.0%-тай гарч, ЗГХЭГ-т хүргүүлээ.

Багийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах зорилгоор эхний хагас жилийн байдлаар 5 багт 40.4 сая төгрөгийн урсгал засвар хийгдэж, зайлшгүй шаардлагатай 15 компьютер, 14 хэвлэгч, 11 чанга яригчийг шинэчилсэн. Мөн бичиг хэргийн зардалд 9.1 сая төгрөг, шатахууны зардалд 36.9 сая төгрөг, томилолтын зардалд 2.1 сая төгрөг, цахилгаан, халаалт, интернет болон бусад зардалд 47.6 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/411 дүгээр захирамжийн 6 дугаар хавсралтаар баталсан “Хөдөөгийн иргэдэд багийн Явуулын төвөөр үйлчилгээ хүргэх журам”-ын дагуу 2020 оны эхний хагас жилд 27 сумын 97 багаас зорилтод бүлгийн давхардсан тоогоор 55587 иргэнд 15 төрлийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: 0-1 насны хүүхдийн үзлэгт 2273, 1-5 насны хүүхдийн үзлэгт 3982, жирэмсэн 1118 эх, төрсөн 596 эх, хэвтрийн 188 өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй 1441 иргэн, ахмад настан 4801, отроор яваа 1213 малчин байна. Харин эрүүл мэндийн үзлэгт давхардсан тоогоор 33784 иргэн хамрагдсан байна.

2020 онд дэлхийн нийтийг хамарсан COVID19 цар тахлын улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хориглож, улсын хэмжээнд хол хорио тогтоогдсон. Иймд төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр иргэдэд хүргэж, оролцоог ханган ажилласны үр дүнд эхний хагас жилийн байдлаар 27 сумын төсөвт 161 байгууллагаас иргэдтэй хийх уулзалт-ярилцлага, хэлэлцүүлэг, өдөрлөг, бусад арга хэмжээг 4523 удаа зохион байгуулахад давхардсан тоогоор 279759 иргэн хандалт хийн хамрагдаж, 1375 санал хүсэлт гаргаснаас 1194 буюу 92.37%-ийг шийдвэрлэлээ.

Засгийн газрын 1111 төвөөс эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 20 өргөдөл гомдол хуваарилагдан ирсний 13 нь шийдвэрлэгдэн 7 шийдвэрлэх

шатандаа байна. “Иргэдээ сонсох өдөр”-ийг 3 удаа Зуунмод сумын 6 багт зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэлтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Сар	Иргэдийн тоо	Гаргаса H санал,	Шийдвэрлэлт			Шийдвэр лэлтийн хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
4		160	160			
5		48	48			
6		53			53	
Дүн		261	208		53	79.69

Аймгийн Засаг даргын 2020 оны А/31 дүгээр захирамжаар батлагдсан “Нэгдсэн төлөвлөгөө”-ний 219 арга хэмжээний хэрэгжилтийг тооцоход 88.29% буюу 4.41 оноотой бөгөөд Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэн болсон.

Байгууллагын ХАБЭАЗ нь 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 14 арга хэмжээтэй баталсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 65.83%-тай байна.

Ерөнхий сайд боловсролын салбар байгууллагууд, цэрэг хүчний байгууллагууд, эмнэлгийн алба хаагчид хийх цахим уулзалтын бэлтгэлийг бүрэн хангаж ажилласан.

Мэдээлэл технологийн газартай хамтран 7 суманд ХУР системийн тоног төхөөрөмжийг гардуулж өгөв.

Үндэсний хөгжлийн газар, Мерит төсөлтэй хамтран “Хөгжлийн бодлого, төлөвлөлт” цахим сургалтад аймгийн ЗДТГ-ын бодлогын мэргэжилтнүүдийг хамруулсан.

2020 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар анхан шатны байгууллагаас ирүүлсэн 112 иргэний материалыг /Үүнээс ТАХ 20/ аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 13 иргэний материалыг /Үүнээс ТАХ 4/ хэлэлцүүлэв. Тайлант хугацаанд “Хүндэт тэмдэг”-ээр-3, Засаг даргын “Хүндэт жуух бичиг”-ээр 7 иргэнийг шагнаад байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Аймгийн хэмжээнд 3 ерөнхий боловсролын сургуулийн захирал, 6 цэцэрлэгийн эрхлэгч, 9 эрүүл мэндийн төвийн эрхлэгч, нийт 18 удирдах албан тушаалын сул орон тооны сонгон 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2020.06.30-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	28
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	5
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	9
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын зар	9
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	1
НИЙТ ДҮН		52

8. 2020 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Албан бичиг	45	11	10	1	-
2	Өргөдөл, гомдол	3	2	1	1	-

Гадаад харилцаа: БНСУ-ын Кёнгги аймгийн Пёнтаек хотын захиргааны дэмжлэгээр хийгдэх аймгийн Нийтийн номын сангийн их засварын ажлын гадаад валютын гүйлгээ, санхүүжилттэй холбоотой шаардагдах материалыг хүргүүлэв.

NEAR-ийн одоогийн тэргүүлэгч орон болох Сахагийн бүгд найрамдах улсаас NEAR-ийн 13 дугаар бүгд хурлыг 2021 он хүртэл хойшлуулах тухай саналыг дэмжсэн албан тоот илгээсэн. 25 дах удаагийн Зүүн хойд Азийн бүс нутгийн захирагчдын дээд хэмжээний уулзалтыг энэ онд зохион байгуулах саналыг уламжлаа.

Япон улсын Изүмисано хотоос үер усны гамшгийн улмаас тохиосон гарз хохиролд эмгэнэл илэрхийлсэн албан бичиг хүлээн авсан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: “Өлзий”, TBS, Төв, Live, Сүлд зэрэг телевизүүдтэй гэрээгээр хамтран ажиллаж, аймгийн веб сайт, пейж хуудас, урсдаг самбар, албаны мэдээллийн самбар, цахим ухаалаг дэлгэц зэрэг мэдээллийн хэрэгслүүдээр цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн веб сайтад **187**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **433** мэдээ мэдээлэл нийтлэгдлээ. Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **18-н** дугаарт **44** бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар **99** мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор **596** удаа цацагдсан байна.

Төрийн үйлчилгээний төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны “Хур” системийг үйлчилгээний төв, 27 суманд нэвтрүүлэн туршилтаар ажиллуулж байгаа бөгөөд **9** байгууллагын **56** төрлийн лавлагаа, үйлчилгээгээр 1471 иргэн үйлчлүүлээд байна.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: 2020 оны эхний хагас жилийн байдлаар 349 төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 239 байгууллага буюу 68.48%-ийг хамруулан хяналт шалгалт хийсэн. 28 нэр төрлийн хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 42 буюу 17.57% их эрсдэлтэй, 113 буюу 47.28% нь дунд эрсдэлтэй, 84 буюу 35,15% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 562 заалттай 113 албан шаардлагаар үүрэг өгч биелэлтийг хангуулан ажилласан. Хүнсний зах, томоохон худалдааны төв, хүнсний дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүний хэрэглэх, хадгалах хугацаа дууссан 151 нэр төрлийн 1495 ширхэг, 26.225 кг, 2008.9 мянган төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч сумын ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус комисст шилжүүлсэн.

Тайлангийн хугацаанд 65 дүгнэлт гаргаснаас /барилгын зурагт эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж улсын байцаагчийн зөвшөөрсөн 34, татгалзсан 4/, бүтээгдэхүүний 20, баталгаажуулах чиглэлээр 8, үйл ажиллагааны чиглэлээр 3 байна.

Улсын байцаагчийн 32 актаас түр зогсоосон-2, сэргээсэн-2, чанарын шаардлага хангаагүй хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан бүтээгдэхүүнийг хураан авсан 28 акт үйлдсэн байна. Хууль тогтоомжийн заалт зөрчсөн 3 объектод 1100 нэгжийн торгуулийн арга хэмжээ ногдуулан 100% барагдуулсан байна.

Зөвлөн туслах үйлчилгээнд 156 байгууллага хамруулахаас 79 байгууллага буюу 50,64% хамруулсан. 14 объект үйл ажиллагаа явуулаагүй. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан объектыг 24 нэр төрлийн хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 8 буюу 10,12% их эрсдэлтэй, 38 буюу 48,1% нь дунд эрсдэлтэй, 33 буюу 41.78% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар 208 заалттай 38 зөвлөмжөөр үүрэг өгч биелэлтийг хангуулан ажилласан.

Төлөвлөгөөт бус шалгалт: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам батлах тухай" 188-р тогтоолын хавсралтаар Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах журам батлагдсан. Энэ журмын хэрэгжилтийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны үе, нам эвсэл, нэр дэвшигчийн ухуулах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах, санал авах байранд хяналт шалгалт хийж ажилласан.

Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр: "Хүүхдийн баяр"-ын 19/04 дугаартай удирдамжийн дагуу Баянцагаан, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Борнуур, Архуст, Баянжаргалан, Баяндэлгэр, Жаргалант сумдын 30 хүнсний худалдаа, 6 нийтийн хоолны газрын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, хадгалалтын хугацаа хэтэрсэн 116 нэр төрлийн 5.88гр, 1349 ширхэг, 1387610 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг хурааж сумын ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. Урьдчилан сэргийлэх шалгалтын явцад Борнуур сумын "Ану зоог" цайны газар нь эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлээгүй нь тогтоогдсон тул үйл ажиллагааг түр зогсоон илэрсэн зөрчлийг арилгуулахаар 17 заалттай, 1 албан шаардлага хүргүүлэн, Довын хайрхан, Эрдэнэ мандал цайны газарт 24 заалттай, 2 албан шаардлагаар хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлэн ажиллалаа.

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр: Улсын баяр наадмын нээлтийн үйл ажиллагааны зураг авалтыг Эрдэнэ сумын "13-р зуун" амралтын газар зохион байгуулахтай холбоотой аймгийн Засаг даргын шийдвэрээр тус нутаг дэвсгэрт эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангуулах ажлыг зохион байгуулсан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь: Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 31 сорьцыг шалгаж хүлээн авч 153 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс: 7 сорьц стандартын шаардлага хангаагүй дүнтэй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд:

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

ХЗДХЯ, Ханс зайделын сантай хамтран "Зууны мэдээ" сонины 7 хоног тутмын "Хуульч зөвлөж байна" асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын "Хуулийн цаг" зохиомжит нэвтрүүлгийн 06 сарын дугаарыг "Өмгөөллийн тухай хууль"-ийн сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 36 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 42 иргэн болон сум, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 15 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангасан.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 6 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 4 шүүх хуралдаанд оролцлоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зарласан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн аяны тайлан, аймгийн ГХУСАЗСЗ-ийн эхний хагас жилийн ажлын тайланг улын зөвлөлд нэгтгэн хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас нэр бүхий сумдад хяналт шалгалтын ажлын хэсэг ажилласантай холбогдуулан 27 сум, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт нийтлэг гарч буй зөрчил, дутагдлуудыг арилгуулах зорилгоор зөвлөмж, чиглэл хүргүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн хавсралтаар батлагдсан “Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын 54, 55 дугаар заалтын дагуу танилцуулах мэдээ, танилцуулах тойм мэдээ, гадаад улсын төлөөлөгчидтэй уулзсан уулзалт, ярианы тэмдэглэл, гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн хэрэгжилт, ҮАБ-ыг хангах чиглэлээр Төв аймагт хийсэн ажлын тайлан, ҮАБЗ-ийн 2019 оны 4/666 тоот чиглэлийн хэрэгжилт, 2020 оны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт, мөн ҮАБЗ-өөс аймагт ажиллаад гаргасан үүрэг чиглэлийн биелэлтийг гаргаж тус зөвлөлд хүргүүллээ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг 27 сум, 27 байгууллагын хяналтад авахуулж, дотоод удирдлагын системээр дамжуулан нийт 3624 ажилтан, албан хаагчдад 10 хичээл, 2 үүрэг чиглэл өглөө.

Архивын үйлчилгээ: Төрийн архивын эх баримтаас 248 иргэний хүсэлтээр 1192 хуулбар хувь, 142 лавлагаа, 273 хөмрөгийн 1192 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилж, 1.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

3 хөмрөгийн 131 хадгаламжийн нэгжийн 772 хуудас баримтын 37489 хүний нэр, 7190 заалтын тоо, тушаалын мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж, 3 хөмрөгийн 131 хадгаламжийн нэгжийн 7693 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 3 хөмрөгийн 342 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: **Эд хөрөнгийн бүртгэл:** Цахим санд нийт 56430 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10618, Газар өмчлөх эрхийн 46673 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 20161.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 95.6 сая төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсны 74.6 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 3.0 төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Тайлант хугацаанд нийт 37 аж ахуй нэгж, байгууллага бүртгүүлснээс 14 нэмэлт өөрчлөлт, шинээр 13 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж, татан буугдсан хуулийн этгээд 4, бусад бүртгэл 6 хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 1 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 1 лавлагаа, иргэнд 8 лавлагаа өгч, орон нутгийн төсөвт 3.1 сая төгрөгийг оруулсан.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн хэмжээнд нийт 428 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хэргээр буюу 3.7%-иар өссөн, хөнгөн гэмт хэрэг 362 бүртгэгдсэн нь 32 нэгжээр буюу 8.8%-иар буурсан, хүнд гэмт хэрэг 66 бүртгэгдэн өмнөх оны мөн үеийнхээс 24.2%-иар буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 44.8% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5%-иар өссөн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Эрүүлжүүлэгдсэн 141 иргэдээс төлбөр болох 585150 төгрөг, хугацаа дууссан 250 хүмүүжигчийн төлбөр 12.9 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Батсүмбэр суманд тусгаарлах 3 байранд 9 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн. Тус Цагдаагийн газраас

Улсын их хурлын сонгуулийн 14 дүгээр тойргийн 96 санал авах байрны 9 удаа, 20 цаг үргэлжилсэн хамгаалалтад 31 алба хаагч, 24 тээврийн хэрэгсэлтэй 155 тусгай хэрэгсэлтэй, 13 станцтай 1136 иргэдийн аюулгүй байдлыг хангалаа.

Шүүх хурлын 1,2,3-р танхимуудад 1319 оролцогчтой Эрүүгийн хэргийн 156, Иргэний хэргийн 145, Захиргааны 9, Хянан магадлангийн 8, нийт 318 шүүх хурлын хамгаалалтад ажилласан. Төв аймгийн Мөнгөнморьт суманд байрлах ШШГЕГ-ын харьяа хорих 417-р ангид хянан магадлангийн 24 оролцогчтой нийт эрүүгийн 8 шүүх хуралдаанд журам сахиулж шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 76 жолоочийг илрүүлж, 34 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 42 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 3393 жолоочийг 118.370.000 / нэг зуун арван найман сая гурван зуун далан мянга/ төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 31 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Криминалистикийн шинжилгээ-72, Магадлан шинжилгээ-72, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-299, гарын мөрийн санг баяжуулсан-172, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 358 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
6 дугаар сар	321	213	27	507	226	281	44.6%
	4335531.9	1210380.8	913340.3	4632572.4	894450.9	3738121.5	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Газар тариалангийн хүрээнд: 2020.06.25-ны байдлаар үр тариа 66616 га үүнээс буудай 60544 га, тэжээл 8394 га, тос 15972 га, төмс 10139 га, хүнсний ногоо 1246.7 га, жимс, жимсгэнэ 18.7 га-д тариалж, тариалалт 90 хувьтай байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 4.1 тэрбумтөгрөгийн техник, усалгааны тоног төхөөрөмж, трактор, чиргүүл, дүүжин машин, бордоо, хөнгөлөлтэй нөхцөлөөр олголоо.

2021 оны хаврын тариалалтад 14 сумын 288 иргэн аж ахуйн нэгж 96.6 мянган га талбайд уринш боловсруулахад шаардлагатай шатахууны судалгааг ХХААХҮЯ-д хүргүүлсэн.

Мал аж ахуйн хүрээнд: Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Лүн суманд малын үзлэг ангилалт зохион байгуулж, Алтанбулаг үржлийн хэсгийн-1200 хонь, Нутгийн монгол-5000 хонь, Өнжүүл үржлийн хэсгийн-200 ямаа, Нутгийн монгол адуу-5210, нийт 11610 толгой хонь, ямаа, адуу хамруулснаар үзлэг ангилалт 90.0 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 3583 толгой бух, 15902 толгой хуц, 10186 толгой ухна үржилд ашиглаж, 12850 хуц, 7753 ухна 99 суурьт ялган төвлөрүүлж, Баяндэлгэр

сумын 6 малчин өрхийн 746 хурга цахилгаан соронзон долгионы аргаар хөнгөлж, ашиг шимийг нэмэгдүүлэх ажил зохион байгуулав.

Орон нутгийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр 14 суманд 100 мян/га талбайд энгийн механик аргаар, улсын төсвийн 487.0 сая төгрөгийн хөрөнгөөр 26 суманд 107.5 мян/га талбайд энгийн механик болон микро биологийн аргаар тэмцэх ажил 82.3%-ийн гүйцэтгэлтэй байна.

ОНТ-ийн 312.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 26 худаг, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 150.0 сая төгрөгийн зардлаар 13 худаг, нийт 468.0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 шинэ инженерийн хийцтэй худаг гаргахаас, 8 цэгт инженерийн хийцтэй худаг гарч, сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. 9 худгийн цэгийг тогтоож, хайгуулын ажил эхэлж, 9 худгийн гэрээ байгуулж, 13 худаг гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. Ажлын гүйцэтгэл 40%-тай.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар ирүүлсэн 44 аж ахуйн нэгжийн төслийн материалын иж бүрдлийг шалган зээлийн программд оруулж, 22 төсөл шалгарч, дараагийн шатны шалгуурлалтад шилжүүллээ.

ХХААХҮЯ, Хоршоологчдын үндэсний холбоотой хамтран сумдын ЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарыг оролцуулан “Хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ хийх, зээлийн батлан даалт” сургалт зохион байгуулж, хоршооны үнэлгээний ажлыг эхлүүлсэн.

Мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян/мал хамруулахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ байгуулж, вакцины нийлүүлэлт 95.6%, вакцинжуулалт 81.04 хувьтай явагдаж байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг 95.0%-тай байна.

Байгалийн давагдашгүй үзэгдэл үерийн улмаас Алтанбулаг, Баян, Сэргэлэн, Зуунмод сумын 87 өрхийн 4913 бог, 29 бод, нийт 4942 мал хорогдсон бөгөөд сэг зэм устгах ажлыг зохион байгуулж, 400 кг хлорын шохой, 16 кг суперкилл ариутгалын бодисоор хангалаа.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр 8754 цахим гэрчилгээ олгож, 1534 дуудлагын дагуу үйлчилгээ үзүүллээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 1313 тээврийн хэрэгсэл, тэмээ 185, адуу 2088, үхэр 1211, хонь 12551, ямаа 2484 толгой мал, 1318,7 тн-мах, махан бүтээгдэхүүн, 125508 ширхэг арьс шир, 24,6 тн ноос, 388,4 тн ноолуур, 13,6 тн цагаан идээ зэрэгт бүтээгдэхүүний эрүүл ахуйн хяналт, мал эмнэлгийн гэрчилгээнд шалгалт хийлээ.

Гоц халдварт шүлхий өвчний тандах шинжилгээнд 450 дээж, 700 малд мялзан өвчний тандах шинжилгээнд тус тус хамрууллаа.

Дэд бүтцийн чиглэлээр:

Барилга хот байгуулалт, газрын харилцааны үйлчилгээний хүрээнд: Засгийн газрын 2018 оны 68, 171, 317 дугаар тогтоолын дагуу эхний хагас жилийн байдлаар 34 барилга байгууламжийг эхлүүлэх зөвшөөрөл олгож, 7 барилга байгууламжид комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад орууллаа.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд захиалагчийн техникийн хяналт тавьж, иргэн, аж ахуйн нэгжийн 12 барилга байгууламжид хяналт хийх гэрээ байгуулав. 6 дугаар сард Эрдэнэ, Архуст, Сүмбэр, Баянцагаан, Зуунмод сумын 5 барилга байгууламжид захиалагчийн техникийн хяналтын гэрээ хийгдсэн.

2020 онд 41 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан батлаад байна. 6 сард архитектур төлөвлөлтийн даалгавар 3 аж ахуйн нэгжид олгож, 5 барилгын зураг төсөл зөвшөөрөгдсөн.

2020 оны 06 дугаар сарын байдлаар газрын төлбөрийн орлого 1,450,000.0 төгрөг төвлөрүүлэхээс 1,539,221.0 төгрөгийг төвлөрүүлж 106.1%-ийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 25 сумын 333 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөснөөс 12 сумын 264 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулж дууслаа.

Түүх соёлын үл хөдлөх 81 дурсгалын байршлын координатыг тодруулж, хамгаалалтын зурвас нийт 5052.19 га газрыг тусгай хэрэгцээнд авах газрын байрзүйн зургийг хийж, мэдээллийн сан үүсгэсэн.

Худалдан авах ажиллагаа, өмчийн хүрээнд: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 39,678.8 сая төгрөгийн 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 36,780.1 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс эхний 6 сарын байдлаар 76 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулснаар хэрэгжилт 93 хувьтай байна.

2019 оны “Улс, орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д бий болсон хөрөнгүүдийг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайланд тусган бүртгэллээ.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 12 өрх, нийт 24 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын төлбөрийн 38,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Зам харилцааны хүрээнд: Зуунмод сумын Ланс багийн чиглэлийн 0.64 км авто замын ажлыг “Төв АЗЗА” ТӨХК-н гүйцэтгэж 6 дугаар сарын 21-ний өдөр авто замын зорчих хэсгийг нээлээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрхаан, Заамар суманд төмөр бетон хоолой барих, Зуунмод сумын УАА-н гэр хорооллын гудамжны авто замын хучилт хийх ажлуудыг эхлүүлээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй Мөнгөнморьт, Алтанбулаг, Эрдэнэсант сумдын чиглэлийн авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн явцад МХЕГ-ын Авто замын хяналтын улсын байцаагчтай хамтран хяналт шалгалт хийж, зөвлөмж үүрэг чиглэл өглөө.

Аймгийн нутаг дэвсгэрт орсон аадар борооноос үүссэн үерийн усны улмаас орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжууд эвдэрч сүйдсэнийг сэргээн засварлах ажил хийгдэж байна.

Үерийн улмаас үүссэн хохирлыг арилгах хүрээнд: 6 дугаар сарын 21-ний 13:10 цагаас 13:56 цагийн хооронд нийт нутгаар бороо орж, хур тунадасны хэмжээ хамгийн их нь Зуунмод суманд 51 мм, Баян суманд 11 мм, Алтанбулаг суманд 16 мм хурдас орж байгалийн гамшигт үзэгдэл болсон. Зуунмод сумын хэмжээнд 181 өрх, 4 орон сууцны В1 давхар усанд автаж, 6 өрхийн гэр үерт урсан 53 хашаа нурж, 3 халаалтын станц ус дүүрсэн, цэвэр усны хоолой задарсан, төв бохирын далан сэтэрсэн, бохирын усны хоолой дүүрсэн зэрэг хохирол үүссэн. Зуунмод суманд үүссэн хохирлыг арилгахаар тусгайлсан чиг үүрэг бүхий мэргэжлийн анги, Онцгой байдлын газар, Төв Чандмань ДЭХГ ОНӨҮГ, УБ ЦТС-ний Зуунмод түгээх төв зэрэг байгууллагууд шуурхай арга хэмжээ авч цахилгаан болон цэвэр, бохир усан хангамжийг хэвийн ажиллагаанд орууллаа. Мөн Онцгой байдлын газар, Төв АЗЗА ХК, Хот тохижуулах газар, Зуунмод сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын албан хаагчид, иргэдийн оролцоотойгоор үерээс үүссэн зам талбан эвдрэлийг сэргээх, үерийн ус зайлуулах хоолой, шуудууны лаг шаврыг цэвэрлэж, онгойлгох, эвдэрсэн дангуудыг нөхөн сэргээх, усанд автсан хашаа

гудам зэрэг шуудуу татах, орон сууцны зоорийн дахрын гаражинд дүүрсэн усыг соруулах, нурсан хашаа хороо ногоон байгууламжийг цэвэрлэх сэргээн босголтын ажлууд хийгдэж байна.

Байгаль орчны чиглэлээр: Бурхан багшийн их дүйчин өдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахад 115 албан байгууллагын 1848 ажилтнууд оролцож, 428.7 тн хог хаягдал, 484 сэг зэм цэвэрлэж, 1.2 сая төгрөг зарцууллаа.

Үерийн улмаас гэмтсэн 165ш мод, 50м хашаа, явган хүний гүүрийг засаж сэлбэлээ.

Олон Улсын Шинэ Нисэх буудлын худалдаа үйлчилгээний түрээсийн СС203-2/13.5М² талбайд үйл ажиллагаа явуулахаар аймгийн “Аялал жуулчлалын холбоо” түрээсийн түр гэрээ байгуулан хамран ажиллахаар боллоо.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс 6 дугаар сарын гүйцэтгэлээр нийт 73 төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулснаар хэрэгжилт 93%-тай байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээний чиглэлээр: Баян, Баянчандмань, Зуунмод, Эрдэнэ сумын худалдаа, үйлчилгээний 15 цэгт бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Сэргэлэн, Зуунмод сумын худалдаа үйлчилгээний 54 цэгийн мөнгөн тооцооны 98 массын хэмжих хэрэгсэл болон Хуст-Ойл, Магнай трейд, Сод Монгол Групп, Гүн Зэгэстэй, Гор газ, Газ Ойл, Синчи Ойл зэрэг аж ахуйн нэгжийн 72 шатахуун түгээх станцын хэмжих хэрэгслийг хянан баталгаажууллаа.

Дархан Сэлэнгэ цахилгаан түгээх сүлжээ ХХК, Зуунмод салбартай байгуулсан гэрээгээр Борнуур сумын 76 өрхийн цахилгаан тоолуурыг баталгаажуулсан.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд Мерит төсөлтэй хамтран Баянцогт сумын Эрүүл мэндийн төвийн 12 ажилтан, албан хаагчдыг ахисан түвшний жендэрийн дүн шинжилгээ цахим сургалтад хамрууллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 сарын 26-ны хуралдаанаар 2015-2020 онд аймгаас баримтлах “Соёлын бодлого”, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцүүлж, 90.2% буюу “Үр дүнтэй” дүгнэгдсэн.

Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт, хилийн зааг баталж, орон нутгийн хамгаалтад авах тухай асуудлыг аймгийн ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-д өргөн барьсан.

ЕБС-д суралцах хугацаандаа сурлага хөдөлмөр, урлаг спортын өндөр амжилт гаргасан 12 дугаар ангийн шилдэг 9 төгсөгчийг шалгаруулж аймгийн Засаг даргын нэрэмжит “Шилдэг төгсөгч” цом, батламжаар шагнаж урамшуулав.

Аймгийн хэмжээнд ЕБ-ын 4 сургууль, 6 цэцэрлэг, 8 ЭМТ-ийн удирдах ажилтны сул ажлын байрны сонгон шалгаруулалт 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдахад Цээл сумын Золбоо цэцэрлэг, Зуунмод сумын Дэгдээхий цэцэрлэгийн эрхлэгч, Сүмбэр сумын ЭМТ-ийн даргын сул ажлын байр нөхөгдлөө.

2019-2020 оны хичээлийн жилийн 4 дүгээр улирлын ажлын тайланг үнэлж, аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/357 дугаар захирамжаар улирлын мөнгөн урамшууллын хувь хэмжээг баталж, ЕБС-ийн 29 захирал 34 цэцэрлэгийн эрхлэгчид үр дүнгийн урамшуулал олгов.

2020 онд аймгийн хэмжээнд 351 эрэгтэй, 446 эмэгтэй, нийт 797 шалгуулагч “Элсэлтийн ерөнхий шалгалт” өгөхөөр бүртгүүлсэн бөгөөд шалгалтыг 2020 оны 07 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл хангалаа. Шалгалт зохион байгуулахтай холбоотой 5,542,000 төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: 2 сургуулийн өргөтгөл, 1 цэцэрлэг, 3 дотуур байр, аймгийн Нийтийн номын сангийн засвар, 3 сумын соёл спортын төвийн барилгын ажлыг эхлүүлээ.

"Сургалт, арга зүйн нэгж"-ээс 19 сургуулийн ЭЕШ өгөх сурагчдыг бичил болон графикт сорилуудад хамруулан 183 багш, 711 сурагч буюу нийт 894 хүнд сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн.

Монгол туургатан театрын үйлчилгээ:

Музейн үйлчилгээ: Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудад байршлын цэг тогтоох, бүртгэх ажлыг 2020 оны 06 дугаар сарын 02-13-ны өдрүүдэд зохион байгуулж 21 сумын 77 түүх, соёлын үл хөдлөх дурсгалд бүртгэл хийлээ.

БНМАУ-ын анхны эмэгтэй Хөдөлмөрийн баатар саальчин А.Авирмэдийн үр хүүхэд, төрөл төрөгсдийн санаачилгаар Авирмэдийн баримлыг хийлгэж, ажил хөдөлмөрийн амжилтыг сурталчлан таниулах буланг 1-р танхимд байгуулсан.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: “Үндэсний бичиг үсгийн баяр”-ыг тохиолдуулан “Бидний бахархал бичиг үсэг” номын үзэсгэлэнг Facebook page хуудас болон веб сайтад байршууллаа. “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуулан иргэд, хүүхэд залуучуудад Алтанбулаг сумын уугуул Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, яруу найрагч Ш.Цэрэндоо гуайн бэлтгэсэн нэвтрүүлгийг вэб сайт, Facebook page цахим хуудсанд байршуулж танилцуулсан. Мөн “Анхдугаар таван жил” 1964 оны сонинг скайнердаж PDF файл болгож цахим санд байршууллаа.

Номын сангийн үндсэн фондоос “Насанд хүрэгчдийн уншлагын танхим”-д **12058** болон “Хүүхдийн уншлагын танхим”-д **7811** хуваарилан нийт **19869** номуудыг электрон каталогит тулгалт хийсэн.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Өсвөрийн шигшээ багийн тэшүүрийн 12, чөлөөт бөхийн 32 тамирчинг нэгдсэн бэлтгэл сургуулилтад гаргалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, аймгийн хэмжээнд “ТӨВ” телевизтэй хамтран “Аз жаргалын микрофон” баярын шууд лайв нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн. Шууд нэвтрүүлгээр аймгийн Засаг дарга бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, хүүхдийн элч Ж.Батжаргал мэндчилгээ дэвшүүлэн Монгол туургатан театрын уран бүтээлчид тоглолт хийсэн. 2019-2020 оны хичээлийн жилд амжилт гаргасан 16 сумын 64 сурагчид “Ажилтын-Од” медаль гардуулж, Гэр бүлийг дэмжих хөтөлбөрт хамрагддаг 270 өрхийн хүүхэд, асрамж халамжийн төвд амьдардаг 12, хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан 3 хүүхдэд ГБХЗХГ-аас бэлэг өглөө.

Аймгийн хэмжээнд 86 төрлийн арга хэмжээг цахимаар зохион байгуулж, 5556 хүүхэд хамруулж, 25 949 700 ₮-ийг сумын хүүхдийн төлөө зөвлөл, Засаг даргын нөөц сан, тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөл болон иргэдийн тусламж дэмжлэгтэйгээр зарцуулж, төсөвт

байгууллагууд, эцг эхийн зөвлөлүүд, эмэгтэйчүүдийн зөвлөл, аж ахуйн нэгж байгууллагууд, ДЗМОУБ ТОНХ, нутгийн зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулж ажилласан байна.

“Хослох урлаг” телевизийн нэвтрүүлгийн 3 дахь дугаарыг “Төв” телевизтэй хамтран зохион байгуулж, Алтанбулаг сумын мянгат малчин С.Бямбанайданг оролцуулж “Хөдөлмөрч гэр бүл”-ээр батламжилж алдаршуулсан.

2020 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Зуунмод суманд болсон байгалийн гамшиг-үерт өртсөн 13 айл өрхөөр орж нөхцөл байдалтай танилцан хоол хүнс, зөөлөн эдлэл, гутал хувцасны тусламж үзүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын зардлаас 7.230.050 ₮ зарцуулсан. Мөн хүчтэй салхи шуурганы улмаас орон гэргүй болсон Баянхангай, Баян сумын 4 айл өрхийг дээрх тусламжид хамрууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2020 оны 6-р сарын байдлаар 1849 иргэнд 2317.2 сая ₮-ийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1185 иргэнд 588.9 сая ₮-ийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1018 иргэнд 358,3 сая ₮-ийн амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж, 723 ахмад настанд 139.5 сая ₮-ийн хөнгөлөлт тусламж, 5210 ахмад настанд 820,7 сая ₮-ийн насны хишиг, 237 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 45.5 сая ₮-ийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 4130 иргэнд 305.7 сая ₮, жирэмсэн 1122 эхэд 155,1 сая ₮-ийн тэтгэмж, алдар цолтой 60 ахмад настанд 55.7 сая ₮, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 6100 эхэд 1246,1 сая ₮-ийн тэтгэмж, Өрх толгойлсон 285 эх /эцэг/-т 239,0 сая ₮, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 12 эхэд 24.0 сая ₮, алдарт эхийн 1, 2-р одонтой 8993 эхэд 1176,4 сая ₮-ийн тус тус олгосон.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 32 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 24 ажил олгогч байгууллага, иргэн, 40 сул чөлөөтэй ажлын байр, 42-н ажилд зуучлагдсан иргэн, 96 шинэ /байнгын болон түр/ ажлын байрны мэдээллийн санд оруулж ажиллалаа. Ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдах 19-н иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 170 гаруй иргэдэд нээлттэй ажлын байрны зарыг танилцуулж, 11 иргэдийг тохирох ажлын байранд зуучилсан.

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд 16 сумын 28 төсөл хэрэгжүүлэгчид нийт 127,0 сая ₮-ийг олгож 48 шинэ ажлын байрыг ХЗЗ-ийн мэдээллийн санд бүртгэсэн.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд Мөнгөнморьт, Эрдэнэ сумын бүтээн байгуулалтын ажилд 25 иргэн ажиллуулж, 8.9 сая ₮-ийн хөдөлмөрийн хөлс олгосон.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс 4 удаа хуралдаж 215 иргэний асуудал хэлэлцсэн шинээр 24 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 163 иргэний ХЧА-ыг сунгаж, 19 иргэний ХЧАлдалтыг цуцалсан.

“Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж мэдээллийн баазад оруулсан 315 хувийн хэргийг шалгаж зөвлөмж өгсөн.

2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон 1755 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт шалгалт хийхэд 31 зөрчил илэрсэн.

Мөн тэжээгчээ алдсаны тэжээгчийн регистрийн дугаар давхардсан 9 тэтгэвэр авагчийн мэдээлэл, хувийн хэргийг шалгаж давхардсан 3 тэтгэвэр авагчид 12.8 сая ₮-ийн улсын байцаагчийн акт тогтоолоо.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд өөрчлөлт оруулах, залруулга хийлгэхээр хүсэлт ирүүлсэн 4 ажил олгогчийн буруутай албан тушаалтанд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийтгэврийн хуудсаар 800.0 мян ₮-ийн торгууль оногдуулж, хариуцлага тооцож, хялбаршуулсан журмаар зөрчлийн хэрэг нээж прокурорт хянуулан шийдвэрлэн ажилласан.

2020 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар 507 ААН-ийн 2759 даатгуулагчийг Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн ослын даатгалын зэрэг 4 сангийн 764,1 сая төгрөгийн шимтгэлээс бүрэн чөлөөллөө.

Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд Татварын ерөнхий газраас ирүүлсэн үйл ажиллагаа нь доголдсон, орлого нь буурсан 48 ААН-ийн 383 даатгуулагчид 76.6 сая ₮-ийн дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн хэмжээнд 14525 тэтгэвэр авагчдад 5.5 тэрбум ₮-ийн тэтгэвэр олгож, 109 даатгуулагч жирэмсэн амаржсаны тэтгэмж 159.6 сая ₮, 99 даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 10.9 сая, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 2 даатгуулагчийн 3.7 сая төгрөг, 30 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж 48.3 сая, нийт 222.5 сая төгрөгийн тэтгэмж олгогдсон байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Аймгийн хэмжээнд 2020 оны 05 сарын байдлаар 457 эх төрж өмнөх оны мөн үеэс 4 тохиолдлоор өссөн ба 458 нярай бүртгэгдсэн байна. Нийт 137823 иргэнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 52675, амбулаторийн үзлэг 59190, идэвхтэй хяналтын 12089 үзлэг хийж гүйцэтгэсэн. Түргэн тусламжийн дуудлагаар 8196 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 2106 буюу 25.88%, осол гэмтлийн дуудлага 232 буюу 2.83%-ийг эзэлж байна. Стационарт 6221 хүн эмчлэгдэн нийт 46849 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7.4 байна.

“Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээ” 2020 оны урианы жилийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлж, анхдагч баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдан 92%-тай дүгнэгдлээ.

Халдварт өвчний сэжигтэй 8 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: хачигт халдвар 1, салхин цэцэг 1, сальмонеллоз 2, цусан суулга 1, гэдэсний бусад бактерит өвчлөл 3 бүртгэгдсэн байна. Тархвар зүйн судалгааг хийж голомтын ариутгал, халдваргүйтгэл хийлээ. Хачигт халдварын 1 сорьцын шинжилгээг ЗӨСҮТ-д хүргүүлсэн.

Урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг 18 аж ахуй нэгжийн 10556 мкв талбайд гүйцэтгэсэн. /Үүнд: Баянбайгаль, Баянхангай, Ахмадын сувилалын тусгаарлах байруудад эцсийн халдваргүйжүүлэлт/

Зуунмод суманд болсон байгалийн гамшгийн дараах халдваргүйжүүлэлтийг ОБГ-тай хамтран 54 айлын хашаа, нүхэн жорлон, нийтийн эзэмшлийн 11400 мкв талбайд 6 сарын 26-27-ны өдрүүдэд гүйцэтгэн ажиллалаа.

Батсүмбэр сумын Баянбайгаль, Баянхангай амралтын газруудад гадаадын орнуудаас ирсэн 95 хүн тусгаарлах байранд хянагдаж байгаад 6 сарын 29-ний өдөр гарч эцсийн халваргүйжүүлэлтийг хийхээр баг томилогдон ажиллаж байна. Гэрийн тусгаарлалтад 91 иргэнийг 22 сумын Эрүүл мэндийн төвийн хяналтад авч ажилласан. Одоогоор 8 хүн хугацаа дуусаагүй ажиглалтад байна.

Орчны эрүүл мэндийн лабораторийн химийн шинжилгээнд 24 ундны усыг 475 үзүүлэлтээр, нян судлалын шинжилгээнд 24 сорьцод 72 үзүүлэлтээр тус бүр шинжилгээг гүйцэтгэв. Нян судлалын шинжилгээнд хамрагдсан сорьцод стандартын шаардлага хангаагүй сорьц 8 байна.

Сонгуулийн 96 хэсгийн хороонд халдваргүйжүүлэлтийг зохион байгуулсан.

ДЭМБ, ЭМЯ-аас зохион байгуулагдаж байгаа Коронавируст халдварын сэргийлэлт, хяналт эмнэл зүйн менежмент сэдэвт сургалтыг 27 сумын СЭМТ, АНЭ, ӨЭМТ-ийн 829 эмч, эмнэлгийн ажилчдад зохион байгуулж, ажлын байран дээр эмнэл зүйн түр зааврын хэрэгжилт, бэлэн байдлыг хангах талаар мэдлэг дадал хэвшүүлж, эрх зүйн орчин бүрдлээ.

2020 онд Эрүүл мэндийн яам, Сангийн яамны хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилттой дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг уялдуулах нь” төслийн хүрээнд сум, өрхийн ЭМТөвүүдэд Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл нийлүүлэх тендэрийн 1-р багцад шалгарсан Азифарм ХХК, 2-р багцад шалгарсан ЭМ ЭС АЙ СИ СИ ХХК-тай хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулан батлуулж, гэрээ байгуулсан.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: Орлогын төлөвлөгөө 5 дугаар сарын байдлаар орон нутаг 1969,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 2077,8 сая төгрөг төвлөрүүлж 105,5 хувьтай, 5,5 хувиар буюу 108,9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 6103,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 7033,9 сая төгрөг төвлөрүүлж 115,2 хувьтай, 930,7 сая төгрөгөөр буюу 15,2 хувиар биелүүлсэн байна. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1358,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 114,0 %-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Бүрэн, Дэлгэрхаан, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр,Сэргэлэн, Угтаал, Эрдэнэсант, Цээл зэрэг 18 сум, 2 шатны төлөвлөгөө тасалсан Баян сум, 1 шатны төлөвлөгөө тасалсан Алтанбулаг, Архуст, Баянжаргалан, Баянчандмань.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Сумдад эхний 05 сарын байдлаар нийт 35204,8 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 16636,5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 11458,7 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 5177,8 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 3783,3 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 3611,0 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 172,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 316.6 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 277.9 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 14190,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 9153.3 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 5037,2 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2020 оны 5-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 159143,5 мянган төгрөгийн авлага, 201032.0 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 53384,1 мянган төгрөг буюу 26.6 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 7891,9 мянган төгрөг буюу 3.9 хувь нь цалингийн өглөг, 5301.7 мянган төгрөг буюу 2.6 хувь нь НДШимтгэлийн өр, 11791.8 мянган төгрөг буюу 5.9

хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 48704.6 мянган төгрөг буюу 24.2 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 73957,9 мянган төгрөг буюу 36,8 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамааралтай 5 салбарын 94 арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 96.09 хувьтай дүгнүүлэн ЗГХЭГ-ын www.new.unelgee.gov.mn цахим санд тайлагнав.

2020 оны эхний хагас жилийн байдлаар МУ-ын хууль-1, УИХ-ын тогтоол-3, УИХ-ын байнгын хорооны тогтоол-3, Ерөнхийлөгчийн зарлиг-2, ҮАБЗ-ийн зөвлөмж-1, ЗГ-ын тогтоол-53, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл-15, ЗГ-ын албан даалгавар-3, нийт 81 шийдвэрийн 146 заалтын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд 90.57%-тай дүгнэгдлээ. Үүнээс 100%-100, 70%-37, 30%-3, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй-6 заалт байна. Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-ын www.new.unelgee.gov.mn цахим санд тайлагнасан.

Бодлогын 6 хэлтэс, Цэргийн штаб, 27 сум, 22 агентлаг, 5 байгууллагын 2020 оны эхний хагас жилийн тайланг [http://tov.unelgee.gov.mn/](http://tov.unelgee.gov.mn) ХШҮЦМС-аар авч дүнг нэгтгэж байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимд оруулах ажлыг “Ухаалаг Засаглал ТББ”-аар гэрээлэн гүйцэтгүүлсэн. 2020 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ЗДТГ-ын нэгж, төрийн албан хаагчийн 2 дугаар улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг цахим санд орууллаа.

Санхүүгийн хяналтын чиглэлээр: Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань сумын политехникийн коллеж, Эрдэнэ сумын МСҮТ, Зуунмод сумын МСҮТ, Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагууд, аймгийн Музей, БСУГ, Монгол туургатан театр, ХХААГ, Баянжаргалан, Баяндэлгэр, Баян, Сэргэлэн сумын төсөвт байгууллагууд, Мал эмнэлгийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Угтаалцайдам сумын төсөвт байгууллагууд, Цээл сумын төсөвт байлгууллагууд, Батсүмбэр сумын эрүүл мэндийн төв, Алтанбулаг сумын ЕБС, Баяннөжүүл сумын ЭМТ, Баянцогт сумын төсөвт байгууллагууд, Аргалант сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 650837.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 180025.5 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 470812.1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 14633.9 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Өмнөх оны актын үлдэгдэл 109224.0 мянган төгрөгөөс 30151.0 мянган төгрөг төлөгдсөн байна. Өмнөх оны актын төлөгдөөгүй үлдэгдлийн судалгааг гаргаж Төв аймгийн Прокторын газарт шилжүүлсэн болно. Нийт актын биелэлт 13,5 хувьтай байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Батлан хамгаалахын сайдын баталсан Цэргийн дүйцүүлэх албаны сургалтын хөтөлбөрийн дагуу 2020 оны 6 дугаар сарын 08-аас 14 хоногийн хугацаатай Батсүмбэр суманд 6 сумын 30 иргэнийг хээрийн байрлалд сургалтанд хамруулсан.